



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 18 өдөр

Дугаар A/64

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн A/43 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан “Аргай бэст ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2018 оны 5 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан “Гишүүнчлэлийн гэрээ”-гээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг “Аргай бэст ҮЦК” ХХК /Э.Болормаа/-д анхааруулсугай.
3. Үнэт цаасны арилжааны програмд нэвтрэх эрх сэргээхийг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд тус тус үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

000212